

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо : 2018 оны 04 дүгээр сарын 12 -ны өдөр

Тендер шалгаруулалтын нэр: Халаалтын зуухнуудыг төвлөрсөн дулаан хангамжид холбох /багц-1/ У-18 цэгээс 7и магистраль ДХ-7138 дугаар цэг хүртэл шинээр 2Ф700мм голчтой дулааны шугамын барилга угсралтын ажил.

Тендер шалгаруулалтын дугаар: ЭХЯ/201812005

Эрчим хүчний яам нь эрх бүхий тендерт оролцогчдоос Халаалтын зуухнуудыг төвлөрсөн дулаан хангамжид холбох /багц-1/ У-18 цэгээс 7и магистраль ДХ-7138 дугаар цэг хүртэл шинээр 2Ф700мм голчтой дулааны шугамын барилга угсралтын ажлыг гүйцэтгэх тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа тул www.tender.gov.mn –хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг үнэ төлбөргүйгээр татан авна уу. Тендерт оролцохын тулд эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр 50,000 төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютаар цахим тендерийн хураамж төлнө. Тендерийн хүчинтэй хугацаа нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоног байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 3 жил /2015, 2016, 2017/ аль нэгэн жилийн борлуулалтын хэмжээ нь тендерт санал болгож буй үнийн дүнгийн **70%**.

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: Санал болгож буй үнийн дүнгийн **70%** буюу түүнээс дээш хувь

Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: Сүүлийн 3 жил: 2015, 2016, 2017 он.

Сүүлийн гурван жилийн аль нэг жилд нь хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг: Санал болгож буй үнийн дүнгийн **70%**-иас багагүй байна.

Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх:

Эрчим хүчний яамнаас олгогдож буй 03.5.2- 0-40.0 кгх/см² даралттай дулааны шугам хоолой, ЦТП-ны угсралт, засварын тусгай зөвшөөрөл.

Зам тээврийн хөгжлийн яамнаас олгогдож буй 2.8.6 Хатуу болон хайрган хучилттай зам засварлах, 2.8.1 Хатуу хучилттай зам барих тусгай зөвшөөрөл.

Тендерийн хамт: **169 000 000 /Нэг зуун жаран есөн сая/** төгрөгийн дүнтэй тендерийн баталгааг ирүүлнэ.

Тендерийг 2018 оны 05 дугаар сарын 14-ны өдрийн 15:00 цагаас өмнө цахим системээр илгээх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2018 оны 05 дугаар сарын 14-ны өдрийн 15:30 цагт Эрчим хүчний яамны хурлын зааланд нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх **эрхтэй:**

Дотоодын давуу эрх **тооцно:**

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Эрчим хүчний яам, 17060 Хан-Уул дүүрэг 3-р хороо, Чингисийн өргөн чөлөө, Засгийн газрын XIV байр, 300-а тоот Утас: 62263061 www.energy.gov.mn